



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/23

Хэрлэн сум

Малын гоц халдварт африкийн гахайн мялзан
өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн шинжилгээгээр 2019 оны 1 дүгээр сард Булган, Төв, Орхон, Дундговь аймгийн зарим сумдад гоц халдварт Африкийн гахайн мялзан өвчин оношлогдсонтой холбогдуулан уг өвчинтэй тэмцэх зааврын дагуу урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Гахайн аж ахуй эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийн бүртгэл судалгааг нарийвчлан гаргах, тандалт, судалгаа хийх, өвчин үүсч болзошгүй цэгүүдэд ариутгал халдваргүйжүүлэлтийг шуурхай зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн газар /даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Анхбаяр/, урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг иргэдэд хүргэх, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг байгууллага аж ахуйн нэгжид хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Г.Сүнгээ/ -т тус тус даалгасугай.

3. Гахайн мах, махан бүтээгдэхүүн худалдан авах, борлуулах тээвэрлэх ажлыг түр хугацаагаар хориглосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж шуурхай удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/, Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Н.Чанцал/, сумдын Засаг дарга нарт нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА